

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/308/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimeg@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 51-261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn "Ирмүүн хантайших аудит" ХХК-ийн захирал: Д.Бямбацэрэн Утас: 77550809 Цахим хаяг: irmuunkhantaishir@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Төлбөрийн акт.....	20
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНДБ	Ази номхон далай бүс
АЦХАФ	Азийн цөмийн хамтын ажиллагааны форум
БНФУ	Бүгд найрамдах франц улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУАЭА	Олон улсын атомын энергийн агенлтар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ЦЭКАА	Цөмийн энергийн комиссын ажлын алба



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тоируу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/453
танай _____-ны № _____-г

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г.МАНЛАЙЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу цөмийн энергийн комиисын ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 19,145.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгөөр 74,739.8 мянган төгрөгийн байгууллагын сан техникийн шугам хоолойг бүрэн хэмжээнд сольж их засвар хийсэн боловч капиталжуулан үндсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэн бүртгэлгүй урсгал зардалд бүртгэсэн;
- Хугацаа хэтэрсэн 8,725.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6, 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар заалтуудтай нийцээгүй бөгөөд эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага нь Монгол Улсын Их Хурал "Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц" болон "Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт", "Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол"-ыг соёрхон баталсан байна.

Тус конвенцуудыг соёрхон баталсан батламж жуух бичгийг 2025 онд Цөмийн энергийн комиссын ажлын албанд хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

АНУ-ын Эрчим хүчний яамны Цацрагийн аюулгүй байдлын газар, Сандиагийн үндэсний лабораторитой хамтран Изотоп конторын барилга, байгууламжийн дэд бүтцийг сайжруулах, цацрагийн 3 дугаар агуулах шинээр барих үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Ажлын албаны даргын 2025 оны А/81 дүгээр тушаалаар барилгыг хүлээж авах комисс байгуулж 2,000,000.0 мянган төгрөгийн Изотоп конторын 3 дугаар агуулахын барилгыг хүлээн авч акт үйлдэн хүлээж авсан, 2026 оны 1 дүгээр улиралд багтаан үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах, эзэмших асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

Бусад асуудал

Цөмийн энергийн салбарын бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны хэлэлцээний Бүсийн төвтэй зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан байна

Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны газрын байцаагч нар Монгол Улсад ажиллаж, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Изотоп контор, Дозиметрийн тохируулга, баталгаажуулалтын лаборатори, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ, МУИС-ын Цөмийн физикийн судалгааны төв зэрэг байгууллагад цөмийн материалын байршил, бүртгэл, тооллогод хяналт шалгалт хийсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,528,533.95	9,100,035.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	11,125,000.00	8,725,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	11,125,000.00	8,725,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,403,553.95	375,035.95
354	Хангамжийн материал	1,403,553.95	375,035.95
35410	Бичиг хэргийн материал	219,104.00	-
35420	Аж ахуйн материал	14,994.00	42,580.00
35440	Түлш, шатах тослох материал	1,169,455.95	2,455.95
35470	Бусад хангамжийн материал	-	330,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,859,142,006.61	3,731,110,660.03
392	Биет хөрөнгө	2,753,562,058.55	2,627,543,721.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,100,543,041.38	2,100,543,041.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(518,083,310.16)	(604,430,528.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,700,000.00	65,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,122,222.20)	(25,355,555.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,416,513,673.93	2,666,299,042.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,405,696,309.93)	(1,650,935,043.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,518,443.00	72,518,443.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,967,191.26)	(34,632,338.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,126,800.76	55,126,800.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,970,866.97)	(16,790,140.65)
393	Биет бус хөрөнгө	1,105,579,948.06	1,103,566,938.82
39301	Програм хангамж	25,759,027.60	25,759,027.60
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,055,501.54)	(22,068,510.78)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,099,876,422.00	1,099,876,422.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,871,670,560.56	3,740,210,695.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	12,833,370.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	12,833,370.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	12,833,370.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,871,670,560.56	3,727,377,325.98
51	Засгийн газрын хувь оролцоо	3,871,670,560.56	3,727,377,325.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,099,876,422.00	1,099,876,422.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,137,306,638.71	993,013,404.13
51210	Өмнөх үеийн үр дүн	1,137,306,638.71	1,137,306,638.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	(144,293,234.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,634,487,499.85	1,634,487,499.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,871,670,560.56	3,740,210,695.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,922,940,605.00	4,525,718,973.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	382,729,105.00	496,221,473.24
120	Нийтлэг татварын бус орлого	382,729,105.00	496,221,473.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	382,729,105.00	496,221,473.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,506,800.00	51,368,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	355,222,305.00	444,853,473.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,540,211,500.00	4,029,497,500.00
122	Тусламжийн орлого	-	4,029,497,500.00
1221	Хандив туслажийн орлого		4,029,497,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,540,211,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,540,211,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,914,526,833.38	4,474,944,103.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,914,526,833.38	4,474,944,103.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,623,612,986.21	1,777,353,299.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,022,977.50	972,525,589.03
210101	Үндсэн цалин	509,974,637.88	574,781,269.24
210102	Нэмэгдэл	139,624,339.62	184,327,619.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	140,484,000.00	140,323,000.00
210104	Урамшуулал	64,940,000.00	73,093,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,005,590.68	116,198,158.18
210201	Тэтгэврийн даатгал	73,326,049.99	78,727,049.63
210202	Тэтгэмжийн даатгал	8,697,629.74	9,895,542.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,305,214.88	4,860,651.31
210204	Ажилгүйдлийн даатгал	4,130,539.20	4,539,382.95
210205	Эрүүл мэндийн даатгал	16,546,156.87	18,175,531.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,893,912.59	56,861,002.19
210301	Гэрэл, цахилгаан	20,788,310.18	35,284,627.71
210302	Түлш, халаалт	9,063,023.25	9,935,452.81
210303	Цэвэр, бохир ус	1,517,579.16	3,100,921.67
210304	Байрны түрээс	9,525,000.00	8,540,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,965,415.06	25,680,155.00
210401	Бичиг хэрэг	2,297,456.00	2,922,687.00
210402	Тээвэр, шатахуун	2,090,000.00	3,167,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,927,276.06	9,912,306.00
210404	Ном, хэвлэл	560,000.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	362,500.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,728,183.00	8,588,162.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,800,000.00	74,739,759.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,800,000.00	-
210604	Урсгал засвар	-	74,739,759.00
2107	Томилолт, зочны зардал	-	897,490.00
210702	Дотоод албан томилолт	-	897,490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	226,638,309.00	152,254,431.00

**Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,813,575.00	83,586,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,234,530.00	1,343,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	455,104.00	1,564,212.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,664,000.00	10,504,600.00
210807	Газрын төлбөр	57,350,100.00	50,189,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	359,286,781.38	378,196,715.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,943,000.00	380,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	348,343,781.38	377,816,715.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	290,913,847.17	2,697,590,803.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,803,427.52	2,518,804,602.86
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	112,803,427.52	2,518,804,602.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,849,100.00	600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,849,100.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	174,261,319.65	178,186,200.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,261,319.65	178,186,200.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	8,413,771.62	50,774,869.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	195,068,104.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	195,068,104.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(195,068,104.50)
5	НИЙТ ҮР ДҮН	8,413,771.62	(144,293,234.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,567,718,300.00	4,083,265,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,506,800.00	53,768,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,506,800.00	53,768,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,506,800.00	53,768,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,540,211,500.00	4,029,497,500.00
122	Тусламжийн орлого	-	4,029,497,500.00
1221	Хандив тусламжийн орлого	-	4,029,497,500.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгуулагад олгосон санхүүжилт шижүүлэгийн орлого	-	4,029,497,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,029,497,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,540,211,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,540,211,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,567,328,300.00	4,083,265,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,567,328,300.00	4,083,265,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,276,414,452.83	1,385,674,696.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,022,977.50	972,525,589.03
210101	Үндсэн цалин	509,974,637.88	574,842,312.72
210102	Нэмэгдэл	139,624,339.62	184,327,619.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	140,484,000.00	140,261,956.52
210104	Урамшуулал	64,940,000.00	73,093,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,005,590.68	116,198,158.18
210201	Тэтгэврийн даатгал	73,326,049.99	78,727,049.63
210202	Тэтгэмжийн даатгал	8,697,629.74	9,895,542.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,305,214.88	4,860,651.31
210204	Ажилгүйдлийн даатгал	4,130,539.20	4,539,382.95
210205	Эрүүл мэндийн даатгал	16,546,156.87	18,175,531.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,893,912.59	56,861,002.19
210301	Гэрэл, цахилгаан	20,788,310.18	35,284,627.71
210302	Түлш, халаалт	9,063,023.25	9,935,452.81
210303	Цэвэр, бохир ус	1,517,579.16	3,100,921.67
210304	Байрны түрээс	9,525,000.00	8,540,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,110,663.06	24,651,637.00
210401	Бичиг хэрэг	2,507,110.00	2,730,583.00
210402	Тээвэр, шатахуун	3,010,600.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,927,276.06	9,912,306.00
210404	Ном, хэвлэл	560,000.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	362,500.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,743,177.00	8,918,748.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,800,000.00	74,739,759.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,800,000.00	-
210604	Урсгал засвар	-	74,739,759.00
2107	Томилолт, зочны зардал	-	897,490.00
210702	Дотоод албан томилолт	-	897,490.00

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	226,638,309.00	139,421,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,813,575.00	70,752,830.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,234,530.00	1,343,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	455,104.00	1,564,212.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,664,000.00	10,504,600.00
210807	Газрын төлбөр	57,350,100.00	50,189,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,943,000.00	380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,943,000.00	380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	290,913,847.17	2,697,590,803.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,803,427.52	2,518,804,602.86
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	112,803,427.52	2,518,804,602.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,849,100.00	600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,849,100.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	174,261,319.65	178,186,200.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,261,319.65	178,186,200.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	390,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	390,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	390,000.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,099,876,422.00	1,635,218,183.45	1,128,162,183.49	3,863,256,788.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	730,683.60	730,683.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,099,876,422.00	1,635,218,183.45	1,128,892,867.09	3,863,987,472.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(730,683.60)	-	(730,683.60)
Тайлант үеийн үр дүн	-	-	8,413,771.62	8,413,771.62
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,099,876,422.00	1,634,487,499.85	1,137,306,638.71	3,871,670,560.56
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,099,876,422.00	1,634,487,499.85	1,137,306,638.71	3,871,670,560.56
Тайлант үеийн үр дүн	-	-	(144,293,234.58)	(144,293,234.58)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,099,876,422.00	1,634,487,499.85	993,013,404.13	3,727,377,325.98

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,078,039,000.00	3,905,079,299.26	172,959,700.74	95.8
12	Татварын бус орлого	4,078,039,000.00	3,905,079,299.26	172,959,700.74	95.8
120	Нийтлэг татварын бус орлого	-	53,768,000.00	(53,768,000.00)	
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого/туслах/	-	53,768,000.00	(53,768,000.00)	
122	Тусламжийн орлого	4,078,039,000.00	3,851,674,299.40	226,364,700.60	94.4
122005	Төсвөөс санхүүжих	4,078,039,000.00	3,851,674,299.40	226,364,700.60	94.4
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,078,039,000.00	3,905,079,299.26	172,959,700.74	95.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,078,039,000.00	3,905,079,299.26	172,959,700.74	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,557,931,300.00	1,385,674,696.40	172,256,603.60	88.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,089,392,800.00	972,525,589.03	116,867,210.97	89.3
210101	Үндсэн цалин	591,605,400.00	574,842,312.72	16,763,087.28	97.2
210102	Нэмэгдэл	226,285,900.00	184,327,619.79	41,958,280.21	81.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	188,011,600.00	140,261,956.52	47,749,643.48	74.6
210104	Урамшуулал	83,489,900.00	73,093,700.00	10,396,200.00	87.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,401,700.00	116,198,158.18	23,203,541.82	83.4
210201	Тэтгэврийн даатгал	94,791,700.00	78,727,049.63	16,064,650.37	83.1
210202	Тэтгэмжийн даатгал	11,166,600.00	9,895,542.59	1,271,057.41	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,580,000.00	4,860,651.31	719,348.69	87.1
210204	Ажилгүйдлийн даатгал	5,572,400.00	4,539,382.95	1,033,017.05	81.5
210205	Эрүүл мэндийн даатгал	22,291,000.00	18,175,531.70	4,115,468.30	81.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,378,400.00	56,861,002.19	1,517,397.81	97.4
210301	Гэрэл, цахилгаан	36,368,800.00	35,284,627.71	1,084,172.29	97.0
210302	Түлш, халаалт	10,761,600.00	9,935,452.81	826,147.19	92.3
210303	Цэвэр, бохир ус	2,695,000.00	3,100,921.67	(405,921.67)	115.1
210304	Байрны түрээс	8,553,000.00	8,540,000.00	13,000.00	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	29,865,200.00	24,651,637.00	5,213,563.00	82.5
210401	Бичиг хэрэг	2,496,000.00	2,730,583.00	(234,583.00)	109.4
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,213,600.00	9,912,306.00	5,301,294.00	65.2
210404	Ном, хэвлэл	250,000.00	250,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	985,500.00	840,000.00	145,500.00	85.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,920,100.00	8,918,748.00	1,352.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,270,800.00	74,739,759.00	4,531,041.00	94.3
	хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,530,900.00	-	4,530,900.00	100
210604	Урсгал засвар	74,739,900.00	74,739,759.00	141.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	897,500.00	897,490.00	10.00	100.0
210702	Дотоод албан томилолт	897,500.00	897,490.00	10.00	100.0

**Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,344,900.00	139,421,061.00	20,923,839.00	87.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,569,200.00	70,752,830.00	20,816,370.00	77.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,343,800.00	1,343,700.00	100.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,564,300.00	1,564,212.00	88.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	108,400.00	66,000.00	42,400.00	60.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,569,400.00	10,504,600.00	64,800.00	99.4
210807	Газрын төлбөр	50,189,800.00	50,189,719.00	81.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,000.00	380,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	380,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,520,107,700.00	2,519,404,602.86	703,097.14	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,518,807,700.00	2,518,804,602.86	3,097.14	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,518,807,700.00	2,518,804,602.86	3,097.14	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	600,000.00	700,000.00	46.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,300,000.00	600,000.00	700,000.00	46.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	30	29	1	96.7
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах үйл ажиллагаа явуулдаг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Цөмийн энергийн комиссын ажлын алба эрхэм зорилгоо “Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх цөмийн болон цацрагийн хамгаалалт аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь үйл ажиллагаандаа Цөмийн энергийн тухай хууль, Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Мөн Монгол улсын ерөнхийлөгчийн “Цөмийн хаягдлын тухай”, “Цацраг идэвхт ашигт малтмал газрын ховор элемент, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай” зарлиг, “Цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- ⊖ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- ⊖ Төрийн албаны тухай хууль
- ⊖ Төсвийн тухай хууль

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтний чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 131.4 сая төгрөгөөр буюу 3.4. хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	11,125.0	8,725.0	(2,400.0)
Бараа материал	1,403.6	375.0	(1,028.6)
Үндсэн хөрөнгө	3,859,142.0	3,731,110.7	(128,031.3)
Нийт хөрөнгө	3,871,670.6	3,740,210.7	(131,459.9)
Өр төлбөр	-	12,833.4	12,833.4
Засгийн газрын хувь оролцоо/ эздийн өмч	3,871,670.6	3,727,377.3	(144,293.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	3,871,670.6	3,740,210.7	(131,459.9)

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 2,400.0 мянган төгрөгөөр буурч, 8,725.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь харилцагч байгууллагаас авах авлагыг барагдуулсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 1,028.6 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл нөөц түлш шатахууныг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 128,031.3 мянган төгрөгөөр буурсан нь 27,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бүртгэлээс хассан, үндсэн хөрөнгөнд 377,816.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан;
Мөн Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн хамтын ажлын хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 249,785.4 мянган төгрөгийн оптик цацаргалтын люминесценцийн дозиметр, WBEXT программ хангамж, дагалдах хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн;
- Өр төлбөрийн дансны үлэгдэл 12,833.4 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу төлөх харуул хамгаалалт, үйлчилгээний 11, 12 дугаар сарын төлбөрийг төлөөгүйтэй холбоотой байна.

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь санхүү бүртгэлийн санхүүгийн тооцоолох “aculous” санхүүгийн программ, албан бичиг хөтлөлтийн эйбл систем, байгууллагын цахим хуудасны удирдлагын системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,339,907.2 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн ирүүлсэн төсвийн төслийн саналыг хэвээр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсантай холбогдуулан бараа, ажил, үйлчилгээний зардлыг 261,860.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 4,078,039.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,029,497.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 53,768.0 мянган төгрөгийг орлого бүрдүүлж, төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 24 арга хэмжээг санхүүжүүлэхэд 3,905,079.3 мянган төгрөгийг зарцуулан 178,186.2 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,905,079.3 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг цалингийн зардлыг 23,203.5 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгэлүүлэх ажил үйлчилгээний зардлыг 20,923.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бараа үйлчилгээний зардал	1,499,552.9	1,328,813.7	170,739.2	88.6
2	Байр ашиглалтын үйлчилгээ	58,378.4	56.861.0	1,517.4	97.4
3	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	2,518,807.7	2,518.804.6	3.1	99.9
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,300.0	600.0	700.0	46.1
Дүн		4,078,039.0	3,905,079.3	172,959.7	95.8

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгадагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Цөмийн энергийн комиссын ажлын албаны даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, орон тоог 33 байхаар баталсан байна. Төсвийн тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой 30 орон тоотой болсон гүйцэтгэлээр 29 хүний орон тоогоор ажиллаж байна.
2. Цөмийн энергийн комиссын ажлын алба нь тайлант онд даргын 2023 оны А/52 дугаар тушаалын дагуу нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 20.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тооцож олгож байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн зардалд 188,011.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 140,261.9 мянган төгрөгийг зарцуулсан.
3. Архив албан хэрэг хөтлөлтийн сургалтанд нийт албан албан хаагчид, архив, цацрагийн хэмжилтийн улсын шалгагчийн сургалтанд нийт 2 хүн хамрагдаж 380.0 мянган төгрөгийн сургалтын зардал гарсан.

4. Ажлын албаны даргын А/17 тоот тушаалаар Өвөрхангай аймагт 2025 оны 04 дүгээр сарыг 05-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Улсын физикийн 36 дугаар олимпиадын үйл ажиллагаанд 1 ажилтан оролцон 897.5 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан
5. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг үндэслэлгүй дутуу төлөвлсөнтэй холбоотой Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээтэй төлбөр тооцоотой холбоотой 12,833.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгууллага нь тайлант хугацаанд нэмэлт эх үүсвэрээс санхүүжилт, орлого төвлөрүүлээгүй зарцуулаагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд засгийн газрын нөөц сангаас багаж техник хэрэгсэл, тавилга эд хогшил худалдан авах 200,000.0 мянган төгрөгийн, байрны түрээсийн үйлчилгээ авах 96,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөө, урсгал төсвөөс багаж техник хэрэгсэл худалдан авах 31,129.3 мянган төгрөгийн, урсгал засвар хийх 75,000.0 мянган төгрөгийн нийт 402,129.3 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Цөмийн энергийн комиссын ажлын алба түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ирмүүн хантайшир аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Норхлоо, аудиторын туслах Д.Отгонсэнгээ нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг Г.Сэр-од, захирал Д.Бямбацэрэн, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Я.Марал-Эрдэнэ, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,914,526.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 19,145.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд байгууллага улсын төсвийн хөрөнгөөр олон нийтийг хамарсан шинэ жил, аялал зугаалга зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахгүй, бичгийн цаас, хор зэрэг бичиг хэргийн зардлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээ, мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн мөнгөн хөрөнгийн үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулан завсрын аудит гүйцэтгэж, мөнгөн хөрөнгө, авлага бараа материалын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 28,540.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин нягталж дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 12,041.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 11,125.00 мянган төгрөгийн авлага барагдуулах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, авлага барагдуулах албан шаардлагыг биелэлт 21.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4, Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	1	11,125.0	1	2,400.0	21.5
2	Зөвлөмж	2	916.0	1	916.0	100
Нийт дүн		3	12,041.0	2	3,316.0	66.7

Өмнөх аудитаар өгсөн “цацрагийн үүсгүүр хадгалалттай холбоотой авлагыг барагдуулж ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлуудад дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан санхүүгийн тайлангийн маягтыг тодорхой болгож сайжруулах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
2. АНУ-ын Эрчим хүчний яамны Цацрагийн аюулгүй байдлын газар, Сандиагийн үндэсний лабораторийн санхүүжилтээр баригдсан цацрагийн 3 дугаар агуулахын зориулалттай 2,000,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий барилга байгууламжийг үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэхийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар УСНББОУС-1, 17 дэх заалтад нийцээгүй нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 176,903.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

Залруулсан алдаа

- Тайлант хугацаанд хандив, тусламжаар авсан 1,321.5 мянган төгрөгийн OSL дозиметрийн иж бүрдэл, 15,106.9 мянган төгрөгийн OSL дозиметрийн гэр, 135,962.3 мянган төгрөгийн хувийн хяналтын OSL, 18,883.5 мянган төгрөгийн захын эрхтний бөгжин дозиметр, 22,660.4 мянган төгрөгийн нүдний линз дозиметр, 1,133.00 мянгантөгрөгийн чанарын хяналтын OSL дозиметрийн иж бүрдэл зэрэг нийт 9002 ширхэг, 195,068.1 мянган төгрөгийн бараа материалаас зарцуулагдаагүй үлдэгдэл 175,062.8 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан;
- Мөн ус буцалгагч, агшин зуур халаагч, ком аяга тавга, плитка, прожектор зэрэг нийт 5 нэр төрлийн 1,840.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч зардлаар бүртгэсэн байна.

Аудитаар нийт 91,898.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд, 8,433.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 8,725.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 74,739.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 91,898.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 72,752.8 мянган төгрөгөөр хэтэрсэн тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн тооцооллыг шалгахад 4 ажилтанд 8,433.3 мянган төгрөгийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Амралтын болон ажилласан хоногийн цалинг давхардуулан олгосон нийт 8,433.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

"Геоинженеринг" ХХК-ийн цацрагийн үүсгүүр багаж, тоног төхөөрөмжийн хадгалалттай холбоотой 2021 онд үүссэн 8,725.00 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 70 дугаар зүйлийн 70.5-д "төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар

тушаалаар баталсан “Аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй холбогдох ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Улсын төсвийн 74,739.8 мянган төгрөгийн хөрөнгөөр байгууллагын сан техникийн шугам хоолойг бүрэн хэмжээнд сольж их засвар хийсэн боловч капиталжуулан үндсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэн бүртгэлгүй урсгал зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцээгүй

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу их засварыг зардлыг хөрөнгийн өртөгт шингээж бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд хандив, тусламжаар авсан бараа материалын үлдэгдэл 175,062.8 мянган төгрөг, худалдан авсан ус буцалгагч, агшин зуур халаагч, ком аяга тавга, плитка, прожектор зэрэг нийт 5 нэр төрлийн 1,840.9 мянган төгрөг, нийт 176,903.7 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн байна.	1	176,903.7			1	176,903.7	1	176,903.7				
Дүн		1	176,903.7			1	176,903.7	1	176,903.7				

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн бодолтыг шалгахад 4 ажилтанд амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.	1	8,433.3	1	8,433.3								

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	"Геоинженеринг" ХХК-ийн цацрагийн үүсгүүр багаж, тоног төхөөрөмжийн хадгалалттай холбоотой 2021 онд үүссэн 8,725.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.	1	8,725.0						1	8,725.0	
3	Улсын төсвийн 74,739.8 мянган төгрөгийн хөрөнгөөр байгууллагын сан техникийн шугам хоолойг бүрэн хэмжээнд сольж их засвар хийсэн боловч капиталжуулан үндсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэн бүртгэлгүй урсгал зардалд бүртгэсэн байна.	1	74,739.8					1	74,739.8		
Нийт дүн		3	91,898.1	1	8,433.3			1	74,739.8	1	8,725.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 115/АДИ50053

Улаанбаатар хот

САГ-2026/308/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт ажилтны ээлжийн амралтын цалингийн бодолтыг шалгахад 4 ажилтанд нийт 8,433,303.00 (найман сая дөрвөн зуун гучин гурван мянга, гурван зуун гурван) төгрөгийн амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цөмийн энергийн ажлын албаны хавсралтад дурдсан 4 ажилчдад амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан олгосон нийт 8,433,303.00 (найман сая дөрвөн зуун гучин гурван мянга, гурван зуун гурван) төгрөгийг буруутай албан тушаалтан Тамгын газрын дарга Б.Баатарцогт, санхүү төсвийн асуудал хариуцсан ахлах нягтлан бодогч П.Номин-эрдэнэ нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн энергийн комиссын ажлын алба дарга /Г.Манлайжав/ хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Д.БЯМБАЦЭРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 547/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/308/НА-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар илэрсэн 8,725,000.00 (найман сая долоон зуун хорин таван мянган) төгрөгийн авлагыг барагдуулах 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 70 дугаар зүйлийн 70.5-д "төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжавт сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /Г.Дамдинням/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН